

Төрийн албаны зөвлөлийн 2019  
оны 03 дугаар тогтоолын  
хоёрдугаар хавсралт

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

#### Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан  
 Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Хууль тогтоомжийн тухай хууль 2015  
оны 05 дугаар сарын 29-ний өдөр

Дагаж мөрдөх огноо:

2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр

#### Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2024 оны 02 дугаар сарын 08-ны өдөр

#### Байгууллагын нэр:

#### Нэгжийн нэр:

Хууль зүйн үндэсний хурээлэн

Хууль зүйн сургалт, судалгааны төв

#### Албан тушаалын нэр:

#### Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Хэлний зөвлөлийн ажлын албаны  
мэргэжилтэн /ЭША/

ТҮШҮ-3

#### Ажлын цаг:

#### Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдрийн 8 цаг

Эко Интернэйшнл Трэйд Тауэр 9  
давхар, 1 дүгээр хороо, Сүхбаатар  
дүүрэг. Улаанбаатар хот

#### Хөдөлмөрийн нөхцөл:

#### Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

#### Албан тушаалын зорилго:

Хууль зүйн нэр томьёотой холбоотой судалгааг шинжлэх ухааны арга зүйн дагуу хийж гүйцэтгэх, хууль зүйн нэр томьёог шинжлэх ухааны үндэслэлтэй оноон тодорхойлох, жигдлэн хэвшүүлэх, нэр томьёотой холбогдсон асуудлаар зөвлөмж гаргах Зөвлөлийн чиг үүрэгт дэмжлэг үзүүлэх, Зөвлөлийн өдөр тутмын ажлыг

хариуцан зохион байгуулна.

**Албан тушаалын зорилт:**

1. Хууль зүйн нэр томьёоны чиглээр судалгаа хийх;
2. Хууль зүйн нэр томьёоны асуудлаар хууль тогтоомжийн төсөлд санал, дүгнэлт өгөх;
3. Эрдэм шинжилгээний судалгааны тайлан бичих, хууль зүйн нэр томьёоны толь бичиг гаргах, өгүүлэл нийтлүүлэх, хурал семинарт илтгэл хэлэлцүүлэг хийх зэргээр судалгааны ажлыг хэрэгжүүлэх;
4. Судалгааны ажил, зөвлөлөөс эрхлэн гаргах холбогдох баримт бичгийг сурталчлах ажлыг зохион байгуулах;
5. Хууль зүйн сургалт, судалгааны төвийн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцох;
6. Зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, зөвлөлийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах;
7. Бусад байгууллага иргэдтэй хууль зүйн нэр томьёоны асуудлаар харилцах, хамтран ажиллах;
8. Байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1. Хууль зүйн нэр томьёоны чиглэлээр хийх судалгааны тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулж, ХЗАА-ны ахлах мэргэжилтнээр хянуулах;</p> <p>2. Хууль зүйн нэр томьёотой холбоотой судалгаа хийх;</p> <p>3. Харьцуулсан судалгаа хийх;</p> <p>4. Хууль тогтоомжийн тухай хуульд тусгасан аргачлалын дагуу судалгаа хийх;</p> <p>5. Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хүсэлтээр хуулийн төсөл боловсруулахад хууль зүйн нэр томьёог шинжлэх ухааны үндэслэлтэй судлан санал гаргах, дэмжлэг үзүүлэх;</p> <p>6. Лавлагаа, мэдээлэл, судлаачийн зөвлөмж, санал боловсруулах;</p>	Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтооолоор батлагдсан аргачлалын дагуу шинжлэх ухааны арга зүйд тулгуурлан суурь болон хавсарга судалгааны ажлыг гүйцэтгэнэ	Г

2 дугаар зорилтын хүрээнд	<p>1. Хууль тогтоомжийн хэл зүй, найруулгыг судлан нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэх үндэслэл шаардлагыг тодорхойлох;</p> <p>2. Хууль зүйн нэр томьёоны асуудлаар хууль тогтоомжийн төсөлд санал, дүгнэлт өгөх.</p>	Хууль зүйн нэр томьёоны асуудлаар хууль тогтоомжийн төсөлд санал, дүгнэлт өгсөн байна.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	<p>1. Олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг, сургалт, семинар бэлтгэл ажлыг хангах;</p> <p>2. Хууль зүйн нэр томьёоны чиглэлээр илтгэл хэлэлцүүлэх;</p> <p>3. Эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж нийтлүүлэх;</p> <p>4. Судалгааны тайлангаар, салбар эрх зүйн хүрээнд хамтарсан болон нэг сэдэвт бүтээл, гарын авлага бэлтгэх.</p> <p>5. Судалгааны ажлын явц, тайлангаар хэлэлцүүлэг зохион байгуулах.</p>	Хурлын бэлтгэл ажлыг хангасан байна. Илтгэл хэлэлцүүлж, өгүүлэл нийтлүүлж, ном, гарын авлага бэлтгэсэн байна.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	<p>1. Зөвлөлөөс эрхлэн гаргах нэр томьёоны толь, холбогдох бусад баримт бичгийг хэвлүүлэх, түгээх, олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;</p> <p>2. Судалгааг эргэлтэд оруулах, нийтийн хүртээл болгох талаар анхаарч ажиллана.</p>	Судалгааны ажлын үр дүнг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр /телевиз, радио сэтгүүл/ дамжуулан сурталчлах, мэдээлэл түгээх, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.	Г
5 дугаар зорилтын хүрээнд	<p>1. Эрхэлж буй ажил үүрэгтэй холбоотой санал боловсруулах, шийдвэр гаргахад санал өгөх;</p> <p>2. Хариуцсан ажлын төлөвлөгөө, тайланг тогтоосон хугацаанд гаргаж байх.</p>	Хүрээлэнгийн болон төвийн өдөр тутмын үйл ажиллагаа хэвийн явагдаж, ажлын үр нөлөө дээшилсэн байна.	Г
6 дугаар зорилтын хүрээнд	<p>1. Зөвлөлийн ажлын төлөвлөгөө, хэлэлцэх асуудлын төлөвлөгөө болон Зөвлөлийн төсвийн төслийг боловсруулах;</p> <p>2. Зөвлөлийн хуралдааны бэлтгэл ажлыг хангах;</p>	Зөвлөлийн үйл ажиллагаа тогтвортой, үр дүнтэй явагдсан байна.	Г, Т

	<p>3. Зөвлөлийг судалгаа, мэдээллээр хангах;</p> <p>4. Зөвлөлийн үйл ажиллагааг монгол судлалын чиглэлийн их, дээд сургууль, судалгааны байгууллага, холбогдох зөвлөлүүдийн үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулах;</p> <p>5. Зөвлөлийн бусад чиг үүрэгт дэмжлэг үзүүлэх.</p>		
7 дугаар зорилтын хүрээнд	<p>1. Хууль зүйн нэр томьёоны сангийн асуудлаар Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн ажлын албатай хамtran ажиллах;</p> <p>2. Иргэд, байгууллагаас ирсэн хүсэлтийг судлах;</p> <p>3. Тухайн асуудлаар шаардлагатай тохиолдолд эрх бүхий судалгааны байгууллагаар санал, дүгнэлт гаргуулан хүсэлт гаргагчид хариу өгөх, холбогдох байгууллагад уламжлах.</p>	Иргэд, байгууллагаас ирсэн хүсэлтийг судалж, хариу өгч, холбогдох байгууллагуудтай хамtran ажилласан байна.	Г
8 дугаар зорилтын хүрээнд	<p>1. Бусад албан хаагчтай албаны хэрэгцээт мэдээллээ шуурхай солилцох</p> <p>2. Албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөж, нэгжийн ажил үүрэгтэй холбоотой үйл ажиллагаанаас гарах баримтыг архивын холбогдох хууль, журмын дагуу бүрдүүлж, хадгаламжийн нэгж болон цахим сан үүсгэн архивд хүлээлгэн өгөх</p> <p>3. Байгууллагын чиг үүрэгт хамаарах асуудлаар ажлын хэсэгт орж ажиллах</p> <p>4. Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, сар бүр биелэлтийг тайлагнах</p> <p>5. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, хөдөлмөрийн дотоод журмыг биелүүлж, мөрдөн ажиллах</p> <p>6. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх</p>	<p>Мэдээлэл нь бодитой, судалгаа, нотолгоотой байна.</p> <p>Стандарт хангасан байна.</p> <p>Ажлын хэсгийн зохион байгуулалтыг хэрэгжүүлж ажилласан байна.</p> <p>Гүйцэтгэлийн төлөвлөгөө хэрэгжүүлж, биелэлтийг хангасан байна.</p> <p>Төрийн албан хаагчийн ёс зүйн сахилга, хариуцлага дээшилсэн байна.</p> <p>Хууль тогтоомжид заасан чиг үүрэг бүрэн хэрэгжсэн</p>	Г

		байна.	
	7. Ажил үүрэгтэй холбоотой удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллах	Биелэлтийг хангасан байна.	Г, Х

### III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Эрх зүйн эсхүл хэл шинжлэлийн бакалаврын зэрэгтэй байх		
Мэргэжил	Эрх зүйч, монгол хэл шинжлэл		
Мэргэшил			
Туршлага	Мэргэжлээрээ 1-ээс доошгүй жил ажилласан байх;		
	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> <li>- Албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээллийг цуглуулж дүгнэх;</li> <li>- Хариуцсан ажлын дагуу мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх;</li> <li>- Гүйцэтгэж буй ажлын явц үр дүнг тайлагнах;</li> <li>- Судалгааны арга зүйн ерөнхий мэдлэгтэй байх;</li> <li>- Тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийх чадвартай байх.</li> </ul>	
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> <li>- Албан тушаалын чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж танилцуулах;</li> <li>- Удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу тодорхой арга хэмжээг зохион байгуулах;</li> <li>- Албан үүргээ гүйцэтгэх явцад гарч болзошгүй эрсдэлийг урьдчилан тогтоох;</li> <li>- Үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах.</li> </ul>	
Ур чадвар	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> <li>- Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах;</li> <li>- Бусадтай ажил хэрэгч харилцааг бий болгох;</li> <li>- Бүтээлч, санаачилгатай ажиллах;</li> <li>- Маргаантай асуудалд хүлээцтэй, нийцтэй ханддаг байх;</li> <li>- Хувийн зохион байгуулалт сайтай байх;</li> <li>- Ажлын цаг ашиглалтаар хамт олныг үлгэрлэн ажиллах.</li> </ul>	
	Бусад	<ul style="list-style-type: none"> <li>- Англи хэл эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэг хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх;</li> <li>- Компьютерын хэрэглээний программ, мэдээллийг орчин үеийн технологи ашиглах, мэдээллийг шуурхай солилцох;</li> <li>- Төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулга зүйн чадвартай байх;</li> <li>- Төрийн болон байгууллага хувь хүний нууцыг хадгалах, хамгаалах.</li> <li>- Шаардлагатай тохиолдолд илүү цагаар ажиллах</li> </ul>	

### IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЬЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

1. Захирал
2. Эрдэмтэн нарийн бичгийн дарга
3. Зөвлөлийн гишүүд
4. Секторын эрхлэгч
5. Хэлний зөвлөлийн ажлын албаны ахлах мэргэжилтэн

Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо: -	Бусад харилцах субъект: <ul style="list-style-type: none"> <li>- Яам, агентлаг, байгууллагын холбогдох мэргэжилтэн;</li> <li>- Ажил, үйлчилгээний талаар хамтран ажилладаг төрийн болон төрийн бус байгууллага.</li> <li>- Иргэн, хуулийн этгээд</li> <li>- Хүрээлэнгийн албан хаагчид</li> </ul>
--	--

#### V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
<p>Албан тушаал: ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА    Б.БААТАРЦОГТ            (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)            20<sup>14</sup> оны 02 дугаар сарын 08 -ны өдөр</p>	<p>Байгууллагын нэр: Хууль зүйн үндэсний хүрээлэн            Шийдвэрийн огноо: 02/02/08            Дугаар: A/12</p>
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:	
Байгууллагын нэр: Хууль зүйн үндэсний хүрээлэн Шийдвэрийн огноо: 02/02/08 Дугаар: A/12 (тамга/тэмдэг) ЗАХИРАЛ	X.ЭРДЭМ-УНДРАХ  (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 20 <sup>14</sup> оны 02 дугаар сарын 08 -ны өдөр